

## АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭР ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭХ ДҮРМИЙН ТӨСӨЛ

### Нэг. Нийтлэг зүйл

1.1 Энэхүү дүрмийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт автотээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт автотээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэлт гүйцэтгэж байгаа гадаад улсын хуулийн этгээд, иргэн энэхүү дүрмийг дагаж мөрдөнө.

1.3 Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд энэхүү дүрэм болон Монгол Улсын хууль, дүрэм, журам, стандарт, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр болон **тээвэрлэлтийн тусгайлсан нөхцөл шаардлагыг** хангаж гүйцэтгэнэ.

1.4 Тээвэрлэгчийн үндсэн үүрэг нь зорчигчийн зорчих эрэлт хэрэгцээг бүрэн хангасан аюулгүй, ая, тухтай, шуурхай тээвэрлэлтийн үйлчилгээг үзүүлэхэд чиглэгдэнэ.

1.5 Зорчигч тээврийн үйлчилгээнд нийтийн тээвэр, жуулчин тээвэр, зохион байгуулалттай болон зорчигч тээврийн захиалгат үйлчилгээ хамаарна.

1.6 Энэхүү дүрэмд тээвэрлэлтийн зарим нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

**1.6.1 “Захиалгат үйлчилгээ”** гэж нийтийн тээвэр, жуулчин тээврийн үйлчилгээнээс бусад зохион байгуулалттай болон гэрээний үндсэн дээр төлбөртэй гүйцэтгэх зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг;

**1.6.2 “Замнал”** гэж зорчигч тээвэрлэх чиглэлийн эхний ба эцсийн зогсоолуудын хоорондох батлагдсан зам;

**1.6.3 “Замналын гэрчилгээ”** гэж тухайн замын нөхцөл байдал, хөдөлгөөнд нөлөөлж болзошгүй авто замын хэсэг болон тухайн чиглэлийн замналын талаарх бүрэн мэдээллийг агуулсан баримт бичиг;

**1.6.4 Замналын зураглал** нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн замналын дагуу явах хөдөлгөөний зураг;

**1.6.5 “Зорчигч тээврийн үйлчилгээ”** гэж зорчигчийн тээврийн хэрэгслээр зорчих эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн үйлчилгээг;

**1.6.6 “Хөдөлгөөний цагийн хуваарь”** гэж зогсоол бүр дээр автобус ирэх болон явах цагийн мэдээллийг агуулсан техникийн баримт бичиг.

**1.6.7 “Зорчигчийн тогтмол тээвэрлэлт”** гэж эрх бүхий байгууллагаас тогтоосон үйлчилгээний чиглэл, цагийн хуваарийн дагуу хийгдэж байгаа нийтийн тээвэрлэлтийн үйлчилгээг;

**1.6.8 “Зорчигчийн тогтмол бус тээвэрлэлт”** гэж тогтмол бус тээвэрлэлтээс бусад зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг;

**1.6.9 “Зорчигчийн тээш”** гэж зорчигч тээврийн хэрэгслийн тээшний хонгилд тээвэрлэхэд өөрийн шинж чанар, жин, хэмжээний хувьд хориглоогүй, зорчигчтой нэг хугацаанд тээвэрлэхээр тээвэрлэгч хүлээн авсан зорчигчийн эд, зүйл, бусад эд хөрөнгө;

**1.6.10 “Зорчигчийн гар тээш”** гэж зорчигч тээврийн хэрэгслийн дотор тээвэрлэхэд өөрийн шинж чанар, жин, хэмжээний хувьд хориглоогүй, зорчигч өөрөө хариуцан авч явах зорчигчийн эд зүйл, бусад эд хөрөнгө;

**1.6.11 “Тээшний тасалбар”** гэж тээвэрлэлтэд хүлээн авсан тээш бүрд зүүх таних тэмдгийг;

**1.6.12 “Такси үйлчилгээ”** гэж төлбөртэй явсан замын урт болон хугацаан дахь үйлчилгээний үнийг тооцох зориулалтын төхөөрөмжөөр тоноглогдсон, тусгай таних тэмдэг бүхий тээврийн хэрэгслээр үзүүлэх үйлчилгээ

1.7 Улс, хот хоорондын нийтийн тээвэр, жуулчин тээврийн үйлчилгээг

автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас, хот доторх болон хот орчмын мөн орон нутгийн нийтийн тээврийн үйлчилгээг аймаг, нийслэлийн Засаг даргаас **эрх олгогдсон байгууллага** тус тус зохион байгуулна.

1.8 Зорчигч тээврийн үйлчилгээг эрх бүхий байгууллагаас тогтоосон үйлчилгээний чиглэлийн **замнал**, цагийн хуваарь, стандартын шаардлага хангасан авто буудал, зогсоол, талбай, авто замын дагуух үйлчилгээний байгууламжаар дамжуулан үзүүлнэ.

1.9 Тээвэрлэлтийг зохион байгуулах **эрх олгогдсон байгууллага нь** зорчигч тээврийн үйлчилгээний нэгдсэн мэдээллийн сан, **алсын зайн** бүртгэл хяналтын нэгдсэн системийн тусламжтайгаар зохицуулалтыг хийнэ.

1.10 Улс хоорондын болон дамжин өнгөрөх зорчигч тээвэрлэлтийг автотээврийн харилцааны тухай олон улсын гэрээний хүрээнд оролцогч талуудын эрх бүхий байгууллагуудын хэлэлцэж, тохиролцсон үйлчилгээний чиглэлийн замнал, хил нэвтрэх зөвшөөрлийн бичигт заасан боомтоор гүйцэтгэнэ.

1.11 Тээвэрлэгч нь автотээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засварыг тогтоосон горимын дагуу гүйцэтгэж, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлага хангасан, техникийн хяналтын үзлэгт заасан хугацаанд хамрагдаж тэнцсэн автотээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг үзүүлнэ.

1.12 Тээвэрлэгч нь автотээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал, тээвэрлэлтийн нөхцөлийг хэрхэн хангасныг шалгах мэргэжлийн алба, хүмүүсийг зохион байгуулан тээвэрлэлтийн даалгаврыг замын хуудсаар баталгаажуулан олгоно.

1.13 Тээвэрлэгч нь зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг зөвхөн тухайн ангиллын мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлнэ.

1.14 Зорчигч нь тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэндэд болон тээвэрлэлтэд аюул хохирол учруулж болзошгүй эд зүйл, тэсэрч дэлбэрэх, идэмхий бодис, буу зэвсэг, мал, амьтныг тээвэрлэхийг хориглоно.

1.15 Зорчигч нь тээврийн хэрэгслийн дотор тамхи татах, хог хаях, согтууруулах ундааны зүйл хэрэглэх, жолоочийн зөвшөөрөлгүй цонх, хаалга онгойлгох, хөдөлгөөний үеэр жолоочтой ярих болон хөдөлгөөний аюулгүй байдалд харшлах үйлдэл хийхгүй байх үүрэгтэй.

1.16 Улс хооронд болон дамжин өнгөрөх тээвэрлэлт гүйцэтгэж буй тээвэрлэгч нь улсын хил орчмын дэглэм, хилийн боомтын журмын талаар зорчигчдод мэдээлж, мөрдүүлэн, хилийн хяналтын албадын ажилтны шаардлагын дагуу ачаа бараа, тээврийн хэрэгслийг үзлэг шалгалтад бүрэн хамруулна.

1.17 Улс хооронд болон дамжин өнгөрөх тээвэрлэлт гүйцэтгэж буй тээвэрлэгч нь тээврийн хэрэгсэл дотор улс хоорондын тээвэрлэлтийн замналын зураглал болон нийтийн анхаарлыг хандуулсан санамжуудыг байрлуулахаас гадна зорчигчдод чиглэлийн дагуух зогсоол, улсын хилээр нэвтрэхтэй холбогдсон зааварчилга зэргийг зарлан мэдэгдэнэ.

## **ХОЁР. НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

2.1 Таксинаас бусад нийтийн тээврийн үйлчилгээг тогтоосон замнал, цагийн хуваариар зохицуулах бөгөөд үйлчилгээний цагийн хуваарь нь зорчигчдоос бага хугацаа зарцуулж ая тухтай, аюулгүй зорчих нөхцөл, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, жолоочийн хөдөлмөрийн хэвийн нөхцөл, автотээврийн хэрэгслийг оновчтой ашиглах боломжийг бүрдүүлсэн байна.

2.2 Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн замналыг тогтоохдоо зорчигч урсгалын хэмжээ, замын хөдөлгөөний эрчим, хүн амын суурьшил, үйлчилгээний байгууламж, сургууль, цэцэрлэгийн байршил, улиралын онцлог зэргийг харгалзан тогтооно.

2.3 Нийтийн тээврийн үйлчилгээний **чиглэлийн замнал, дугаарыг** Автотээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 8.4-т заасны дагуу эрх бүхий байгууллага тогтооно.

2.4. Эрх бүхий байгууллагаас тогтоосон нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн замналыг энэхүү дүрмийн 1.7-д заасан эрх олгогдсон байгууллага замналын гэрчилгээний баримт бичгийг хөтөлнө.

2.5. Улс хоорондын зорчигч тээвэрлэлтийг Олон улсын автотээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд оролцогч талуудын эрх бүхий байгууллагын хэлэлцэн тохиролцсон чиглэлийн замнал, цагийн хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

2.6. Нийтийн тээврийн үйлчилгээг зөвхөн өөрийн өмчлөлийн тээврийн хэрэгслээр гүйцэтгэх бөгөөд тээврийн хэрэгсэл бүрийг байршил тогтоох төхөөрөмж болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

2.7. Тээвэрлэгч нь нийтийн тээврийн үйлчилгээнд тавигдах шаардлага болон өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангаж чадахгүйд хүрэх, үйлчилгээг хэвийн явуулах боломжгүй байгаагаас бусад тохиолдолд түүний тээвэрлэлтийн гэрээний хүчинтэй байх хугацаанд өөр аж ахуйн нэгж, байгууллагад адил нөхцөлөөр тухайн замналд гэрээ байгуулахыг хориглоно.

2.8 Нийтийн тээврийн үйлчилгээний тухайн чиглэлийн замналд тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэхээр хэд хэдэн сонирхогч этгээд хүсэлт гаргасан тохиолдолд уг ажил, үйлчилгээний **эрэлт, хэрэгцээг харгалзан сонирхогчдын дунд Иргэний хуулийн 421 дүгээр зүйлийн дагуу төсөл шалгаруулах журмаар эрх олгож болно.**

2.9 Дараах шаардлагыг хангаж буй аж ахуйн нэгж байгууллагатай нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулах **эрх олгогдсон байгууллага** тээвэрлэлтийг гүйцэтгүүлэх тухай гэрээ байгуулан ажиллана:

2.9.1 Автотээврийн тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартаар тээвэрлэгчид тавигдах шаардлагыг бүрэн хангасан байх;

2.9.2 Тээвэрлэлтийг тогтвортой, аюулгүй, шуурхай гүйцэтгэх, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, санхүү эдийн засаг, мэргэжлийн хүний нөөцийн чадавхтай байх;

2.9.3 Тээвэрлэлтийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх, шинэ техник, технологи, үйлчилгээ нэвтрүүлэх төлөвлөгөөтэй байх.

2.9.4 Үйлчилгээг хөгжүүлэх төлөвлөгөө нь гэрээний салшгүй хэсэг байна.

2.9.5 Гэрээнд үйлчилгээний чиглэлийн замнал, замналын зураглал, цагийн хуваарь, тээвэрлэлтийн зохион байгуулалт, зохицуулалтын асуудлууд, зорчигч болон зорчигчийн тээшийг тээвэрлэх үнэ тарифыг тусгасан байна.

2.10 Нийтийн тээврийн хэрэгсэл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн зорчих зориулалтын төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон буюу зорчигчдыг тээврээр зорчих хүртээмжтэй орчинг бүрдүүлсэн байна.

2.11 Нийтийн тээврээр зорчих тасалбар худалдаалах, цахим төлбөрийн карт цэнэглэхийг зорчигчийн терминал, авто буудал, автобусны буудал болон цахим систем, автомат түгээгүүр болон бэлнээр худалдаалах зэргээр зохион байгуулна.

2.12 Хотын дотор, хот орчим болон хот хоорондын нийтийн тээврийн хэрэгслээр зорчигч нь 60х40х20 см-ээс илүүгүй овор хэмжээтэй 20 кг хүртэл жинтэй, улс хоорондын тээвэрлэлтэд 30 кг хүртэл жинтэй тээшийг гар тээшийн хамт үнэ төлбөргүй авч явна.

2.13 Энэхүү дүрмийн 2.13-т зааснаас илүү овор хэмжээ, жинтэй зорчигчийн тээшийг тухайн замналд явах зорчигч тээврийн хэрэгслийн даац, багтаамжаас илүү гарсан

үед битүүмжлэл сайтай автотээврийн хэрэгслээр тээвэрлэх ажлыг тусад нь зохион байгуулна.

**2.14 Эрх олгогдсон байгууллага нь** хэмжээ шинж чанараараа бусад тээшинд нөлөөлөхгүй, тээврийн хэрэгсэлд шууд ачих боломжтой бүрэн бүтэн сав, баглаа, боодол бүхий тээшийг хүлээн авах, шаардлагатай гэж үзвэл тээшийг ангилан зориулалтын сав баглаа, боодлоор баглаж тээвэрлэх, хүргэлтийн үйлчилгээг зохион байгуулахтай холбоотой **заавар, журмыг** гарган хэрэгжүүлнэ.

2.15 Тээвэрлэлтийг зохион байгуулах эрх олгогдсон байгууллага нь зорчигчдын тээшийг хүлээн авч тээвэрлэлтэд бэлтгэн хүлээлгэн өгнө. Харин галын аюултай, тэсэрч дэлбэрэх, хортой болон орчныг бохирдуулах зэрэг үйлчлэлтэй аюултай тээш, ил задгай тээш, хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүнийг хүлээн авч хадгалахыг хориглоно.

2.16 Тээш хадгаламжид зорчигчийн тээшийг хадгалахаар хүлээн авч, баримт олгох бөгөөд уг баримтаар хүлээлгэн өгнө. Зорчигч нь тээшээ тээвэрлүүлэхээр хүлээлгэн өгөх, хадгалуулахдаа зохих хөлсийг төлнө.

2.17 Зорчигч тогтоосон хэмжээнээс илүү овор хэмжээ, жинтэй тээш тээвэрлүүлэх тохиолдолд тээшний тасалбарыг зорчигчийн тасалбараас тусад нь олгох, тээшний тасалбарыг үндэслэн буцаан олгоно. Хэрэв тээшний тасалбар байхгүй үед тээшийг хүлээн авах эрх бүхий этгээд гэдгийг баталсан хангалттай нотлох баримтыг бүрдүүлсэн тухайн иргэнд тээшийг олгож болно.

2.18 Улс, хот хооронд, орон нутгийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгсэлд сул суудал байгаа тохиолдолд энэ талаарх мэдээллийг авсны үндсэн дээр зорчигчдод тухайн чиглэлийн замналын дагуух дундын зогсоол дээр зорчих тасалбар бичиж үйлчилнэ.

2.19 Такси үйлчилгээнд энэхүү журмын зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн хамаарах бөгөөд дараах нэмэлт зохион байгуулалтыг авч хэрэгжүүлнэ:

2.19.1 такси үйлчилгээ нь тогтоосон замнал, чиглэл, цагийн хуваарь харгалзахгүй, таксометрийн тусламжтайгаар зорчигчийн нийт зорчсон зай /замын урт/-аас хамааран тээвэрлэлтийн үнэ төлөх бөгөөд зөвхөн хот, хот орчим болон аймаг, сум суурин газрын хооронд үйлчилнэ;

2.19.2 тээвэрлэгч нь такси үйлчилгээний төлбөрийг тогтоосон жишиг тариф болон тээвэрлэлтийн гэрээний дагуу зорчигчдод үйлчилнэ. Таксины жолооч зорчигчийг хүргэхдээ аль болох дөт замыг сонгон явна;

2.19.3 такси үйлчилгээний тээврийн хэрэгсэл нь үйлчилгээг шуурхай зохион байгуулах, жолооч, зорчигчдын аюулгүй байдлыг хангах, хяналт тавих зорилгоор холбоо, мэдээллийн хэрэгсэл болон байрлал тогтоох, бүртгэл хяналтын төхөөрөмжтэй байна;

2.19.4 тээвэрлэгч нь таксины тоолуурын баталгаажуулалтад хамрагдаж, тасалбар хэвлэгдэн гарах төхөөрөмжөөр тоногдсон, тухайн орон нутгийн захиргааны байгууллагын тогтоосон нийтлэг мөрдөх үнэ, тарифыг баримтлан зөвхөн тоолуураас хэвлэгдэн гарсан баримтаар хөлсийг авна;

2.19.5 таксигаар зорчигч нь зөвхөн таксины тоолуурт заасан заалт, баримтыг үндэслэн үйлчилгээний хөлсийг төлөх бөгөөд тээш тээвэрлэсний хөлсийг давхардуулан төлөхгүй;

2.19.6 такси дуудлагын үйлчилгээ хүссэн үйлчлүүлэгч нь диспетчерт дуудлага өгч тэмдэглүүлэх ба диспетчер нь жолоочид очих газрын байршил, цаг хугацааг тодорхой өгч үйлчлүүлэгчид мэдэгдэнэ. Диспетчер мэдэгдсэнээс хойш 10 минутын хугацаанд үйлчлүүлэгч ирэхгүй тохиолдолд захиалга цуцлагдсанд тооцно;

2.19.7 такси дуудлагын хүлээлгийн хугацаа, төлбөр нь тоолуурын заалтаар гарах бөгөөд төлбөрийг заалтын дагуу зорчигч төлнө. Хүлээлгийн хугацааны төлбөр нь 1км-

т зорчих төлбөрөөс бага байна. Хэрэв үйлчлүүлэгч захиалгыг цуцлах бол захиалга өгснөөс хойш 10 минутын дотор диспетчерт мэдэгдэнэ.

## **ГУРАВ. ЖУУЛЧИН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

3.1 Жуулчин тээврийн үйлчилгээг энэхүү дүрмийн 1.7-т заасан тээвэр зохион байгуулах **эрх олгогдсон байгууллагад** бүртгүүлснээр эрхлэх ба жуулчин тээврийн үйлчилгээ нь жуулчдын аяллын хөтөлбөрийн дагуу зорчих үйлчилгээг үзүүлнэ.

3.2 Жуулчин тээвэрлэлтийн замналыг жуулчны хөтөлбөрт нийцүүлэн тухайн жуулчны үйлчилгээний байгууллага тогтооно.

3.3 Жуулчин тээврийн үйл ажиллагааг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан Аялал жуулчлалын байгууллагын ангилал тогтоох журмын дагуу ангилал тогтоолгосон байгууллага, иргэн эрхлэн явуулна.

3.4 Жуулчин тээвэрлэгч нь дор дурдсан үүрэг хүлээнэ.

3.4.1 жуулчин тээврийн үйлчилгээг эрх бүхий байгууллагаас тогтоосон ангиллын хүрээнд гүйцэтгэнэ;

3.4.2 жуулчин тээвэрлэлтийг зөвхөн автотээврийн хяналтын системд бүртгэгдсэн, "TOURIST – ЖУУЛЧИН" наалт, таних тэмдэгтэй жолооч, тээврийн хэрэгслээр гүйцэтгэх;

3.4.3 аялал, жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон аяллын замнал, замналын зураглал, цагийн хуваарийн дагуу жолоочийн хөдөлмөр, амралтын горимыг баримтлан тээвэрлэлтийг явуулах;

3.4.4 аялал жуулчлалын байгууллагуудын захиалгаар гадаадын жуулчны өөрийн хүсэлтэд зориулсан тээврийн хэрэгслээр үйлчилгээг үзүүлэхдээ тухайн аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй гэрээ байгуулсан байх;

3.4.5 тээвэрлэлтийн явцад байнгын мэдээлэл, холбоотой ажиллах, шаардлагатай тохиолдолд техникийн түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах;

3.4.6 тээвэрлэгч нь жуулчин тээвэрлэлтэд ажиллах жолооч нарыг эрүүл мэнд, нийгмийн даатгалд бүрэн хамруулах, жолооч нэг бүртэй хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллана.

3.4.7 тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах үүднээс тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгсэл болон жолоочийн бэлэн байдлыг шалгасан баримтыг бүрдүүлэх, аяллын өмнө холбогдох зааварчилгааг өгсөн байх

3.5 Жуулчин тээврийн жолооч дор дурдсан шаардлагыг хангаж, үүрэг хүлээнэ.

3.5.1 нийтийн тээврийн үйлчилгээний стандартын хүний нөөцийн хөгжилд тавих шаардлагыг бүрэн хангасан байх;

3.5.2 гадаад хэлний зохих мэдлэгтэй байх ба шаардлагатай тохиолдолд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх мэдлэг, чадвартай байх

3.5.3 жуулчдыг суудалдаа бүрэн суусны дараа аялал эхлэхээс өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгыг хөтчийн тусламжтайгаар өгөх;

3.5.4 жуулчин тээвэрлэлтэд хөтөчгүйгээр тээвэрлэлт гүйцэтгэхийг хориглоно.

## **ДӨРӨВ. ЗАХИАЛГАТ ҮЙЛЧИЛГЭЭ**

4.1 Захиалгат үйлчилгээнд сургуулийн хүүхэд, байгууллагын ажилчид тээвэрлэх

дотоодын тээвэр болон иргэд, байгууллагын захиалгаар тусгай үйлчилгээний зориулалтаар тээвэрлэлтийн гэрээний үндсэн дээр төлбөртэй гүйцэтгэж буй үйлчилгээ хамаарна.

4.2 Сургуулийн болон сургуулийн өмнөх насны хүүхэд, байгууллагын ажилчдыг тээвэрлэх үйл ажиллагааг энэхүү дүрмийн 1.7-т заасан эрх олгогдсон байгууллагад бүртгүүлэх, **“Захиалгат үйлчилгээ” таних тэмдэг бүхий** өөрийн тээврийн хэрэгсэл эсхүл нийтийн тээвэрлэлт гүйцэтгэж буй тээвэрлэгчийн тээврийн хэрэгслээр тээвэрлэлтийн гэрээний үндсэн дээр зохион байгуулна.

4.3 Захиалгат үйлчилгээ гүйцэтгэх тээврийн хэрэгсэл нь “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2011, “Хүүхэд тээвэрлэх автобус. Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага” MNS 6440:2014 стандартад заагдсан нөхцөл шаардлагыг бүрэн хангасан байна.

4.4 Захиалгат үйлчилгээнд хөдөлгөөн эхлэхийн өмнө зорчигчийн эрх үүрэг, тээвэрлэлтийн аюулгүй байдлын зааварчилгаа өгөх, автобуснаас буух үед хяналт тавих ба хүүхдийн тээвэрлэлтэд хүүхдэд туслах үүрэгтэй насанд хүрсэн нэг хүний хамт ажиллана.

4.5 Жолооч нь захиалгат үйлчилгээ эхэлсэн, дууссан цаг болон үйлчилгээний явцын мэдээллийг цаг тухай бүр тээвэрлүүлэгчид мэдэгдэж замын хуудсанд тэмдэглэгээ хийлгэнэ.

4.6 Байгууллагын ажилчид, сургуулийн хүүхэд тээвэрлэх замнал, цагийн хуваарийг тухайн байгууллага өөрөө тогтооно.

## **ТАВ. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮНЭ, ТАРИФ**

5.1. Нийтийн тээврийн үйлчилгээний зорчигчийн тарифыг Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7-д заасан жишиг тарифт нийцүүлэн гэрээгээр зохицуулна.

5.2. Нийтийн тээврийн хэрэгслээр зорчигчийн тээшиг энэхүү дүрмийн 1.7-д заасан эрх олгогдсон байгууллага, тээвэрлэгчтэй байгуулах тээвэрлэлтийн гэрээгээр зохицуулна.

5.3. Нийтийн тээврийн үйлчилгээнд төлбөрийн цахим систем ашиглаж болох бөгөөд энэхүү систем нь улсын хэмжээнд нэгдмэл байна.

5.4. Хот доторх болон хот орчмын нийтийн тээврийн үйлчилгээний тарифыг тухайн аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тогтооно.

5.5. Жуулчин тээвэр болон захиалгат үйлчилгээний үнэ тарифыг тээвэрлэгч, тээвэрлүүлэгч нар гэрээгээр зохицуулна.

5.6. Улс, хот хоорондын зорчигчийн байнгын тээвэрлэлтэд бага насны буюу 0-5 насны хүүхдийг тусдаа суудал эзлэхгүйгээр зорчихоор бол үнэгүй, хэрэв тусдаа суудал захиалах бол 60 хувь, 6-12 хүртэлх насны хүүхдийг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр зорчино.

## **ЗУРГАА. ТЭЭВЭРЛЭЛТИЙН БАРИМТ БИЧИГ**

6.1. Зорчигч тээвэрлэлтийн баримт бичигт тээврийн хэрэгслийн гэрчилгээ, уг тээврийн хэрэгслийн ангилалд хамаарах жолоодох эрхийн болон мэргэшсэн жолоочийн үнэмлэх, зорчигч тээврийн хэрэгслийн техникийн хяналтын гэрчилгээ, тээвэрлэлтэд ажиллах жолоочийн үйлчилгээний даалгаврын хуудас (замын хуудас), жолоочийн “хяналтын хуудас”, зорчигчийн тасалбар, тээшний тасалбар, улс, хот хооронд, жуулчин тээвэрлэлтэд зорчигч тээврийн дагалдах хуудас, тээврийн хэрэгслийн хувийн хэрэг тус тус хамаарна.

6.2. Улс хооронд болон дамжин өнгөрөх тээвэрлэлтэд автотээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын олон улсын гэрээ, хэлэлцээр, түүнийг хэрэгжүүлэх протоколын хүрээнд тухайн улстай тохиролцож, баталгаажуулсан загварыг, хэрэв тухайн улстай тээвэрлэлтийн баримт бичгийн загварыг тохиролцож баталгаажуулаагүй тохиолдолд энэхүү дүрмийн 6.3 дахь заалтыг дагаж мөрдөнө.

6.3. Тээвэрлэлтийн баримт бичгийн загвар болон хэвлүүлэх, ашиглах асуудлыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу нийтээр дагаж мөрдөнө.

6.4. Хот хооронд, орон нутгийн байнгын тээвэрлэлтийн зорчигчийн тасалбарыг дор дурдсан хэлбэрээр зохион байгуулна.

6.4.1 зорчигчийн тасалбар нь тийз болон цахим төлбөрийн баримт байж болно;

6.4.2 зорчигчдод цахим шуудангаар суудлын захиалгыг төлбөрийн хамт урьдчилан хийх боломжоор хангана.

6.4.3 зорчих тасалбар худалдаалах төлбөрийн машин (TVM /ticket vending machines/ буюу цахим тасалбар, мэдээлэл өгөх зориулалт бүхий машин)-аар тасалбар олгож болно.

6.4.4 зорчих тасалбар олгох үйлчилгээг иргэдэд ойртуулах үйл ажиллагааг аймаг, нийслэл, хот, сум, суурин газар бүрд зорчигчийн терминал, авто буудал болон байнгын ажиллагаатай харилцаа, холбоо, шатахуун түгээвэр, худалдаа үйлчилгээний газруудыг түшиглэж зохион байгуулна.

6.4.5 TVM /ticket vending machines/-аас хэвлэгдэн гарсан тасалбар болон төлбөрийн карт дахь QR болон бар кодын хүчинтэй эсэхийг хянах тусгай төхөөрөмжөөр тээвэрлэгчийг хангасан байна.

6.4.6 тасалбар худалдах үйл ажиллагааг автобус хөдлөхөөс 5 минутын өмнө зогсооно. Тасалбар худалдах газрын байршлаас хамаарч авто буудлын дарга энэхүү хугацааг өөрчилж болно.

6.4.7 зорчигч нь улс, хот хоорондын зорчигчийн байнгын тээвэрлэлтийн зорчих тасалбараа буцаах бол нийтийн тээврийн хэрэгсэл хөдлөхөөс 4-өөс доошгүй цагийн өмнө урьдчилан худалдан авсан зорчих тасалбарын үнийг эргүүлж авах, харин энэ хугацаанаас хожуу боловч хуваарьт тээврийн хэрэгсэл хөдлөхөөс өмнө тасалбараа буцаасан тохиолдолд тээвэрлэгч тогтоосон үйлчилгээний хөлсийг **15** хувиар суутган, тасалбарын үнийг эргүүлэн өгнө.

6.5 Хот доторх, хот орчмын байнгын тээвэрлэлтийн зорчигчийн тасалбарыг дор дурдсан хэлбэрээр зохион байгуулна.

6.5.1 зорчигчийн тасалбар нь цахим төлбөрийн карт болон төлбөрийн зориулалт бүхий эд зүйл байж болно.

6.5.2 төлбөрийн цахим картын загварт хүүхэд, ахмад, оюутан, хөнгөлөлттэй зорчигчийн, энгийн гэсэн агуулгыг багтаасан байх бөгөөд картын хэмжээ, лого зураг, логоны хэмжээ, үсгийн фонт, үсгийн хэмжээ, картын дугаар, дугаарын хэмжээ, картын төрлийн мэдээллийн хэмжээ, QR болон бар кодын хэмжээ зэргийг тус тус багтаана.

6.5.3 Зорчигчийн сонирхолд нийцүүлэн эд зүйлд төлбөрийн зориулалт бүхий QR болон бар кодыг суурилуулан ашиглаж болно.

6.5.4 **06-18 насны** ерөнхий боловсролын сургуулийн хүүхдэд тэврээр зорчих 50 хувийн хөнгөлөлт бүхий төлбөрийн карт олгоно.

6.5.5 Цахим төлбөрийн карт дор дурдсан хугацааны хүчинтэй байж болно.

а/ цахим төлбөрийн карт нэг буюу түүнээс дээш жилээр ашиглах боломжтой, урьдчилсан төлбөр хийх, хөнгөлөлттэй үнээр зорчих боломж бүрдсэн байх;

б/ тухайн сарын хугацаанд хүчинтэй байх буюу тогтоосон хоногоор урамшуулал хэлбэрээр ашиглах боломж бүрдсэн байх;

в/ нэг удаа зорчих төлбөрийн картыг бэлэн мөнгөөр худалдан авч зорчих ба хөнгөлөлт үзүүлэхгүй.

6.6 Зорчигч нь цахим төлбөрийн картыг гээгдүүлбэл шинээр шуурхай олгох ба иргэний үнэмлэхээр бичигдсэн бол гээгдүүлсэн картыг хүчингүй болгож, төлбөрийн үлдэгдлийг шинэ карт уруу шилжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

6.7 Төлбөрийн цахим картыг засварлах, хуурамчаар үйлдэхийг хориглоно.

## **ДОЛОО. ТЭЭВЭРЛЭЛТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ**

7.1 Авто зам, гүүр түүний байгууламжийг эзэмшигч нь автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саатал учруулахгүйгээр осол, зөрчилгүй, саадгүй зорчих бэлэн байдлыг хангана.

7.2 Эрх олгогдсон байгууллага нь тээвэрлэлтийн явцад гарсан зам, тээврийн хэрэг, зөрчил, техникийн саатал, үйлчилгээний зөрчил, дутагдал, иргэдээс ирсэн гомдлын талаарх мэдээлэл, судалгаатай байх ба зам, тээврийн хэрэг, зөрчил гарсан үед **“Тээвэр ашиглалтын үйл ажиллагааны дүгнэлт”-ийг** гаргасан байна.

7.3 Тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр тээвэрлэгч нь дор дурдсан ажлыг зохион байгуулна.

7.3.1 нийтийн тээврийн үйлчилгээний мэргэшсэн жолооч нарт хөдөлгөөнд оролцохын өмнө ажлын зааварчилга өгөх, зам тээврийн хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, дадлагыг зохион байгуулах;

7.3.2 Автотээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал, тээвэрлэлтийн нөхцөлийг хэрхэн хангасныг шалгаж, үйлчилгээний даалгаврын хуудаст тэмдэглэх мэргэжлийн алба, ажилтныг ажиллуулах;

7.3.3 Хөдөлгөөн эхлэхийн өмнө зорчигчдод зөв суух, бүс бүслэх, гар тээш болон хөдөлгөөний аюулгүй байдлыг сахих зааварчилга өгч хэвшүүлэх;

7.3.4 Улс, хот хоорондын нийтийн тээвэрлэлтийн чиглэлийн замналын замын урт, цаг хугацаанаас хамаарч шөнийн цагийн тээвэрлэлт үргэлжлэн гүйцэтгэх үеийн аюулгүй байдлыг хангах, түр хугацаагаар зогсох үед урьдчилан зорчигчдод хандан анхааруулга санамж өгөх, хөдлөхөөс өмнө зорчигчдыг бүртгэж, бүрэн болсон үед хөдөлгөөнийг үргэлжлүүлэх.

## **НАЙМ. ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА**

8.1. Зорчигч тээвэрлэлттэй холбоотой тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн хооронд үүссэн маргааныг Иргэний хуулийн 35 дугаар бүлэгт заасны дагуу шийдвэрлэнэ.